



Баянхонгор аймгийн Галуут суманд ОУИТБС-ын өдөрлөг зохион байгуулсан тухай тайлан

2014 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр

ОУИТБС-ын ажлын алба Баянхонгор аймгийн Галуут сумын ИТХ, ЗДТГ-тай хамтран 2014 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр ОУИТБС-ын өдөрлөгийг зохион байгуулав.

Өдөрлөгийн зорилго нь ОУИТБС-ыг орон нутагт хэрэгжүүлэх, салбар зөвлөлийн үйл ажиллагааг бэхжүүлэх, чадавхжуулах, орон нутгийн иргэдийг мэдээллээр хангах, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн харилцан ойлголцол, хамтын ажиллагааг сайжруулах, тусгай зөвшөөрөл эзэмшигч, алт үйлдвэрлэгч компаниудын тайланг иргэдэд нээлттэй мэдээлэх, талууд нэгдсэн ойлголтод хүрэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх, сумын салбар зөвлөл байгуулахад оршиж байв.

Уулзалтад Улаанбаатар хотоос Авилгатай тэмцэх газар, Татварын ерөнхий газар, Стандарт хэмжилзүйн газар, Монголын Алт үйлдвэрлэгчдийн холбоо, Уул уурхайн үндэсний ассоциац, Монголын байгаль орчны иргэний зөвлөл, Иргэний Нийгмийн “ТАН” эвсэл, ОУИТБС-ын ажлын албаны зохицуулагч, санхүүгийн мэргэжилтэн бүхий 9 хүний бүрэлдэхүүнтэй баг оролцов.

Орон нутгаас Баянхонгор аймгийн ОУИТБС-ын дэд зөвлөлийг төлөөлж аймгийн ОУИТБС-ын дэд зөвлөлийн гишүүн, СХЗХ-ийн дарга Рэгзэн, нарийн бичгийн дарга Хүрэлсүх, БОХ-ын байцаагч Мөнхтоогоо, Наранбаатар, аймгийн ОНХХ-ийн мэргэжилтэн Энхтогтох, болон зэргэлдээх Баян-Овоо сумын засаг дарга Пүрэвсүрэн, сумыг төлөөлж засаг дарга Баттулга, ИТХ-ын дарга Батсайхан, засаг даргын орлогч Дүүрэнбилэг, багийн дарга нар, ИТХ-ын тэргүүлэгч, төлөөлөгчид, ЗДТГ-ын мэргэжилтнүүд, Шижир аранжин, Монголболгаргео, Жи энд Ноу гоулд компаниудын удирдлага, харьяа уурхайнуудын дарга нар болон нутгийн иргэд, нийтдээ 44 хүн энэ арга хэмжээнд оролцлоо. Бүртгэлийг хавсаргав.

Хөтөлбөрийн дагуу өдөрлөгийн эхэнд ОУИТБС-ын ажлын албанаас санаачилгын хэрэгжилт, ач холбогдол, ОУИТБС-ын орон нутагт хэрэгжих шаардлага, хэрэгцээ, сургалт сурталчилгааны сэдвүүдээр танилцуулга хийв.

Удаагаар Татварын ерөнхий газрын улсын Д.Энхтуяа Засгийн газрын ОУИТБС-ын тайлагналын байдал, эрдэс баялагийн салбараас улсын болон орон нутгийн төсөвт төлж буй татвар, төлбөрүүдийн тухай, Авилгатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Г.Сарангэрэл авилгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, мэдээллийн ил тод байдлын тухай, Монголын алт үйлдвэрлэгчдийн холбооны ажлын албаны дарга С.Бүрэнтогтох алтны салбарын өнөөгийн байдал, цаашдын хандагын тухай, Стандарт хэмжил зүйн газрын сорьцын албаны байцаагч Лутсүх алтны үйлдвэрлэл, сорьцын албаны түүхийн тухай, Байгаль орчны иргэний зөвлөлийн удирдах хорооны гишүүн Б.Батболд ОУИТБС-ын шинэ стандарт, шаардлага орон нутагт түлхүү ач холбогдол өгсөн баримт бичиг болох тухай, Хонгор нутгийн дуудлага ТББ-ын тэргүүн Батболд Баянхонгор аймагт явагдаж үйл ажиллагааны талаар тус тус танилцуулга хийсэн байна.

Булган аймгийн ОУИТБС-ын дэд зөвлөлийн үйл ажиллагааны тухай дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга Хүрэлсүх танилцуулж, Галуут сумын хөгжил, хэтийн төлөв, өнөөгийн

байдлын тухай сумын ИТХ-ын дарга нар ажил хариуцсан мэргэжилтнүүдийн хамт дэлгэрэнгүй танилцуулгыг хийв. Танилцуулгыг хавсаргав.

Өдөрлөгийн эцэст асуулт хариултын цагаар сонирхолтой харилцан яриа хэлэлцүүлэг өрнөсөн байна. Орон нутгаас үзүүлэх дарамт шахалт багассаныг компаниудын төлөөлөл онцолж байв. Орон нутгаас хүмүүс авч ажиллуулах явдал ихсэх хандлагатай байна. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоог цөөрүүлэх нь чухал гэдгийг хаана хаанаа ойлгох хэрэгтэй байна. Усны асуудал хүндэрч болзошгүй байгааг анхааруулав. Үйлдвэрлэлийн усны төлбөрийг аймагт, ундны усны төлбөрийг суманд авч байгаа бөгөөд усны нөхөн төлбөрт бололцооны санхүүгийн эх үүсвэртэй болох бололцоотой. Галуут суманд бараг 200 жил уул уурхайн том жижиг үйлдвэрлэл явагдаж байгаагаас билчээр хомсдох аюул нүүрлэж байна. Компаниуд орон нутгаас сүү аваад мах авахгүй байгаа нь болимоор байна. Нутгийн удирдлага авхаалж самбаатай бол жишиг сум болоход тун ойрхон байна. Нөгөө талаас, малын тоо толгой замбараагүй нэмэгдснээс билчээрийн даацад уул уурхай гэхээсээ илүү мал өөрсдөө нөлөөлж байхыг хаана хаанаа анхаарах хэрэгтэй байна гэжээ.

АТГ-аас өдөрлөгийн зохион байгуулалт, иргэдийн оролцооны талаар шүүмжилснийг сумын удирдлага хүлээн авч, арга хэмжээ авч давтахгүй байхаа амлав.

Дараа нь Баянхонгор сумын Галуут сумын Олон талт хамтын ажиллагааны зөвлөлийн нээлттэй хурлыг зохион байгуулав. Сумын ИТХ-ын дарга Батсайхан удирдан зохион байгуулав. Хурлын гол зорилго нь ОТХАЗ-ийн үйл ажиллагаанд ОУИТБС-ын чиг үүргийг нэмэж оруулах, эсхүл ОУИТБС-ын салбар зөвлөлийг бие даалган байгуулах эсэх, 2014-2015 онд салбар зөвлөлөөс хийх ажлыг боловсруулах, аймгийн жишиг сум болоход хамтран ажиллах, Ажлын албатай уялдаа холбоотой ажиллах асуудлыг хэлэлцэв. Ажлын албанас 2014-2015 онд дараахь чиглэлээр ажиллах зүйтэй гэсэн асуудлыг танилцуулсан байна. Үүнд:

1. Оролцогч талуудад сургалт, семинар, хэлэлцүүлэг зохион байгуулах;
2. Орон нутгийн ОУИТБС-ын тайлан гаргах, хэвлэн нийтлэх, танилцуулах;
3. Мэдээллийн төв эсхүл самбар байгуулж, ажиллуулах;
4. Төсвийн ил тод байдал, шилэн дансны төслийг хэрэгжүүлэхэд холбогдох хэлтэстэй хамтран ажиллах;
5. Орон нутгийн хөгжлийн хэлэлцүүлэг, шийдвэр гаргахад оролцох, мэдээллээр хангах;
6. Жил бүр ажлаа төлөвлөн, төлөвлөгөө батлуулж ажиллах;
7. Орон нутагт ашигт малтмал, байгаль орчины тухай хуулиудыг хэрэгжүүлэхэд оролцох;
8. Орон нутгийн гэрээний биелэлт, хандив тусламжийн ашиглалтыг тайлагнаж байх
9. Үйл ажиллагаа, зорилтын талаар хэвлэмэл хуудас, материал хэвлүүлж, тараах;
10. Орон нутгийн олон талт хэлэлцүүлэг, чуулган зохион байгуулах;
11. Төв, орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах;

Хурлаас Галуут сумын ОУИТБС-ын салбар зөвлөлийг 10 дугаар сарын 15-ны дотор байгуулахаар тогтов.

Санхүүжилт, зардлын тухай

Өдөрлөгийн баннер, оролцогчдын үдийн цайны зардал, УБ-аас оролцох төлөөлөгчдийн унаа, байрны зардлыг Ажлын албанаас санхүүжүүлсэн болно. Аймгаас болон бусад сумаас оролцсон төлөөлөгчдийн зардлыг Ажлын алба хариуцсан байна.

Тайлан бичсэн:

Ш..Цолмон

Санхүүгийн мэргэжилтэн

А.Отгонтунгалаг